



## ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2020 оны 09 сарын 15 өдөр

Дугаар A/399

Арвайхээр

### Г Захирамжийн хавсралтад өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5.б, 29.3, Боловсролын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Засаг даргын дэргэдэх Боловсрол, соёл, урлагийн газрын 2020 оны 183 дугаар албан бичгээр ирүүлсэн дүгнэлтийн дагуу Арвайхээр сумын ерөнхий боловсролын 1 дүгээр сургуульд аймгийн Засаг даргын 2012 оны а/75 дугаар захирамжаар олгосон тусгай зөвшөөрлийн 0000276 дугаар гэрчилгээний хавсралтад дурдсан сургалт явуулах чиглэлд гүнзгийрүүлсэн сургалт англи хэл 8-12 дугаар анги гэснийг 6-12 дугаар анги болгон өөрчилсүгэй.

2. Дээрх өөрчлөлтийн дагуу Арвайхээр сумын ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн тусгай зөвшөөрлийн гэрчилгээний хавсралтыг өөрчлөн, бичилтийг хийж, англи хэлний 6-12 дугаар ангийн гүнзгийрүүлсэн сургалтыг зохион байгуулахыг аймгийн Засаг даргын дэргэдэх Боловсрол, соёл, урлагийн газар (Ж.Пүрэвсүрэн)-т даалгасугай.

ОРЛОГЧ

О.БАТЖАРГАЛ



011100893

D:My Doc. Zahiramj. Zasag darga